



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь заалт, Хамтын гэрээний 6.8, 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан тус газарт бүртгэлтэй ахмадын нэрсийг хавсралт ёсоор баталж, ахмадуудыг 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авах арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Ахмадуудад олгох тэтгэмжид зарцуулагдах 2.460.000 /хоёр сая дөрвөн зуун жаран мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас, гарын бэлгэнд зарцуулагдах 385.400 /гурван зуун наян таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас тооцож гаргахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /П.Долгормаа/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНБААТАР

